

Иргэд байгууллагын захиалгаар дүрс бичлэг хийх журам**Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Энэхүү журам нь ХЗҮТ-ийн "Есөн туг" теле студ /цаашид энэ журамд "Теле студи" гэнэ/ -ээс иргэд, байгууллагатай хамтран эрх зүйн сэдвээр сургалтын видео бичлэг, баримтат кино хийж, хувилах, ХЗҮТ-д зохион байгуулагдаж буй цаг үеийн үйл явдал, сургалт семинар, хурал, зөвлөгөөний үед дүрс бичлэг хийж үйлчлэх зэрэг үйл ажиллагааг зохицуулахад оршино.
- 1.2. Теле студээр үйлчлүүлэх байгууллага, хувь хүн гэрээг бичгээр хийж, төлбөрийг бэлнээр болон дансаар хийнэ.
- 1.3. Теле студийн үйлчилгээний төлбөрийг бусад теле студийн үйлчилгээний тарифийг үндэслэн зах зээлийн үнээр хийнэ.
- 1.4. ХЗҮТ-д зохиогдож байгаа сургалт-семинар, уулзалт ярилцлагын дүрс бичлэгийг байгууллага ба зохицуулагчийн хүсэлтээр хийж төлбөртэй үйлчилнэ.
- 1.5. Хууль эрх зүйн сургалт-семинарын дүрс бичлэгийн үйлчилгээг ХЗҮТ-ийн үндсэн нэгжийн захиалгаар хийвэл захирлын тушаалыг үндэслэнэ.
- 1.6. Теле студийн эрхлэгчийн зөвшөөрлөөр бусад мэргэжлийн байгууллагатай хамтарч, төлбөртэй нэвтрүүлэг, зар сурталчилгаа, баримтат кино, теле зохиомж хийхэд студийн тоног төхөөрөмжийг ашиглаж болно.
- 1.7. Теле студийн тоног төхөөрөмж, байрыг түрээслүүлэх буюу хувь хүнд ашиглуулахыг хориглоно.
- 1.8. Теле студийн шаардлагатай материал, засвар үйлчилгээ, бүтээлч ажилтны урамшилд олсон орлогоосоо зарцуулж болно.
- 1.9. Баримтат кино, бүрэн хэмжээний теле зохиомж бүтээх, олон өдрийн сургалт-семинарын бүрэн бичлэг хийх болон хувилахад захиалагчийн саналыг үндэслэн урьдчилсан төлөвлөгөө гаргаж ХЗМСТ-ийн даргаар батлуулна.

Хоёр. Дүрс бичлэг, теле зохиомж, баримтат кино бүтээхэд гүйцэтгэгч, захиалагч дараах эрх үүрэгтэй

- 2.1. Захиалагч нь: Теле зохиомж, баримтат киноны зохиол, сценарийг урьдчилан өгч зураг авах, бичлэг хийх боломжоор хангана.
- 2.2. Төлбөр, зардалынхаа 50 хувийг урьдчилж төлнө.
- 2.3. Захиалгын дагуу гүйцэтгэлд хяналт тавих эрхтэй.

Гурав. Гүйцэтгэгчийн эрх үүрэг.

- 3.1. Гүйцэтгэгч нь: Гэрээний хугацааг мөрдөж, гүйцэтгэлийн чанарт анхаарна.

159

3.2. Теле студийн техник, төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангана.

3.3. Гэрээний заалтын биелэлтэд шаардлага тавих эрхтэй.

Дөрөв.Хүлээлгэх хариуцлага.

4.1..“Есөн туг” теле студийн эрхлэгчийн зөвшөөрөлгүйгээр тоног төхөөрөмжийг гадагш гаргахыг хориглоно.

4.2. Зөвшөөрөлгүй тоног төхөөрөмж авч гарсан ажилтныг ХЗҮТ-ийн хөдөлмөрийн дотоод журмын дагуу сахилгын арга хэмжээ авч, Хөдөлмөрийн тухай хуулийн /135,136 дугаар зүйлд/ холбогдох бусад хууль тогтоомжид заасан үндэслэл, журмыг баримтална.